



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/18

Мандалговь

Томуу, томуу төст өвчний бэлэн байдал,
хариу арга хэмжээ авах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/482 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчний тархалт нэмэгдэж аймгийн хэмжээнд амбулаторийн үзлэгийн 25,7 хувь, түргэн тусламжийн дуудлагын 54,0 хувийг эзэлж аймгийн хэмжээнд дэгдэлтийн түвшинд ирсэн тул сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагт шилжүүлэн ажиллуулсугай.

2. Томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдлыг ханган, урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг эрчимжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж ажиллахыг эмнэлэг, эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

3. Томуу, томуу төст өвчний тархалтын байдалд тандалт хийж мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (Б.Саруулцэцэг), эмнэлгийн тусламж үйлчилгээнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Л.Ганбат)-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Ц.Энхсайхан)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Б. Алтантөгс* Б.АЛТАНТӨГС